



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 28 өдөр

Дугаар А/408

Ховд

Жуух бичгээр шагнах тухай

Аймаг, нийслэлийн Засаг даргаас олгох шагналын тухай Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоолын 1-ийн “Е”, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан “Аймгийн шагналын журам”-ын 1.2.8, 3.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шүүхийн байгууллагын үйл ажиллагааны бэлэн байдлыг хангах, ард иргэдэд түргэн шуурхай үйлчлэх нөхцөл бүрдүүлэхэд үнэтэй хувь оруулан хамт олноо манлайлан үр бүтээлтэй ажиллаж буй Ховд аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн туслах М.Мянганбаяр, шүүхийн Тамгын газрын шүүх хуралдааны нарийн бичгийн дарга О.Ням-Адъяа нарыг аймгийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр шагнасугай.

2. Аймгийн Засаг даргын жуух бичгээр шагнагдсан М.Мянганбаяр, О.Ням-Адъяа нарт 1 сарын хугацаанд үндсэн цалингийн 20 хувиар тооцож урамшуулал олгохыг Шүүхийн Тамгын газрын дарга /Д.Даваасүрэн/-д зөвлөсүгэй.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН